



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/А28

Булган сум

“Дархлаажуулалтын үйл ажиллагаанд олон нийтийн эрүүл мэндийн ажилтан нарын оролцоог бэхжүүлэх нь” сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан 2024 оны А/484, А/231 дүгээр тушаал, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, 2025 оны VI дугаар хуралдааны “Эрүүл Булган хөтөлбөр батлах тухай” VI/32 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Дархлаажуулалтын үйл ажиллагаанд олон нийтийн эрүүл мэндийн ажилтан нарын оролцоог бэхжүүлэх нь” сургалтын удирдамжийг 1 дүгээр, сургалтын хөтөлбөрийг 2 дугаар, зардлын төсвийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Сургалтыг үр дүнтэй зохион байгуулан, дархлаажуулалтын ач холбогдол, вакцины талаарх үнэн зөв мэдээллийг түгээхэд удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т даалгасугай.

3.Дээрх сургалтад зарцуулагдах 7,226,000 (долоон сая хоёр зуун хорин зургаан мянган) төгрөгийг “Эрүүл Булган хөтөлбөр”-ийн арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6325011018

Аймгийн Засаг даргын 2025 оны
11 дүгээр сарын 21-ны/ний өдрийн
А/А.28 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



**“ДАРХЛААЖУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОЛОН НИЙТИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТАН НАРЫН ОРОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ НЬ”
СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

Зорилго: Дархлаажуулалтын ач холбогдол, вакцины талаарх үнэн зөв мэдээллийг түгээхэд олон нийтийн эрүүл мэндийн ажилтан нарыг чадавхжуулах, эцэг эхчүүдэд чиглэсэн дархлаажуулалтын талаарх буруу ойлголт, цуурхалд хариу арга хэмжээ авах ур чадвар олгох орон нутагт ОНЭМА сүлжээг идэвхжүүлж, мэдээллийн урсгалыг сайжруулах

Хамрах хүрээ: Орон нутгийн Эрүүл мэндийн байгууллагын нийгмийн эрүүл мэндийн ажилтнууд, орон нутгийн 95 олон нийтийн эрүүл мэндийн ажилтан

Хариуцах байгууллага зохион байгуулагч: Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн газар

Хамтран ажиллах байгууллага: Сайн дурын нийгэмлэг, Халдварт өвчин судлалын үндэсний төв

Санхүүжилт: “Эрүүл Булган хөтөлбөр”

Хаана: Булган аймгийн Засаг даргын тамгын газрын хурлын зааланд

Хугацаа: 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр


Хийгдэх үйл ажиллагаа:

- ХПВ-ийн эсрэг вакцинжуулалтын ач холбогдол, үр нөлөөний талаар танилцуулга хийх
- Дархлаажуулалтын талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх мэдээлэл, харилцааны арга зүйг судлах
- Эрүүл мэндийн мэдээллийг түгээх ур чадварыг хөгжүүлэх дасгал, хэлэлцүүлэг зохион байгуулах
- Сургалтад оролцогчдын мэдлэг, ур чадварыг үнэлэх асуулга бөглүүлэх
- Сургалтын дүнг нэгтгэж, цаашдын үйл ажиллагаанд санал, зөвлөмж гаргах

Хүлээгдэх үр дүн:

- Оролцогчид ХПВ-ийн эсрэг вакцинжуулалтын ач холбогдол, үр нөлөөг үнэн зөв мэдээллийг түгээх, оновчтой тайлбарлаж чаддаг болно.
- Олон нийтийн дунд эрүүл мэндийн мэдээллийг зөв түгээх мэдлэг, чадвартай болно.
- Дархлаажуулалтын талаарх буруу ойлголтыг засах, зөв мэдээлэл хүргэх харилцааны ур чадвар эзэмшинэ.
- Сургалтын дараа оролцогч бүр өөрийн нутаг дэвсгэрт мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагаа зохион байгуулах төлөвлөгөө боловсруулах чадвартай болно.
- ХПВ-ийн эсрэг вакцинжуулалтыг дэмжих, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр манлайлан ажиллах хандлага төлөвшинэ


Аймгийн Засаг даргын 2025 оны
М. дүгээр сарын 24-ны/ний өдрийн
А/А28 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



**“ДАРХЛААЖУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОЛОН НИЙТИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН АЖИЛТАН НАРЫН ОРОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ НЬ”
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

д/д	Сэдэв	Цаг	Үргэлжлэх хугацаа	Хариуцах мэргэжилтэн
1	2	3	4	5
1	Сургалтын бүртгэл, нээлт	09:00-09:20	20 минут	Зохион байгуулагч нар
2	Олон нийтийн эрүүл мэндийн ажилтан нарын үүрэг, оролцоо	09:20-09:50	30 минут	НЭМҮТ
3	Булган аймгийн халдварт болон халдварт бус өвчлөлийн өнөөгийн байдал	09:50-10:30	40 минут	НЭМХ-ийн дарга Д.Нарантуяа
Цайны завсарлага 10:30-11:00				
4	“Хүний папиллома вирус ба урьдчилан сэргийлэлт”	11:00-11:30	30 минут	ХӨСҮТ
5	Олон нийтийн мэдээлэл түгээх, харилцааны ур чадвар	11:30-12:00	30 минут	НЭМҮТ
6	Хүний папиллома вирусийн (ХПВ) халдварын эсрэг вакцинжуулалтыг эрчимжүүлэх, олон нийтийн мэдээлэл, ойлголтыг нэмэгдүүлэх нь	12:05-12:40	35 минут	ХӨСҮТ
Үдийн завсарлага 12:50-14:00 60 минут				
7	Дархлаажуулалтын ач холбогдол, үр дүн	14:05-14:40	35 минут	ХӨСҮТ
8	Хувь хүн ба хамт олны манлайлал	14:50-16:25	35 минут	НЭМҮТ
9	Эрүүл мэндийн мэдээллийг түгээх ур чадварыг хөгжүүлэх дасгал, хэлэлцүүлэг зохион байгуулах	16:30-17:30	60 минут	ХӨСҮТ
10	Интерактив арга - “Мэдлэгийн сорил”	17:30-18:00	Зохион байгуулагч нар	

Аймгийн Засаг даргын 2025 оны
М. дүгээр сарын 21-ны/ний өдрийн
А/А28 дугаар захирамжийн 3 дугаар хавсралт



**“ДАРХЛААЖУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОЛОН НИЙТИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН АЖИЛТАН НАРЫН ОРОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ НЬ”
СУРГАЛТЫН ТӨСӨВ**

д/д	Зарцуулалт	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Үнэ (төгрөг)	нийт	Тайлбар
1	2	3	4	5	6	7
1	Багш нарын ирэх, буцах зардал	ш	3	240,000	720,000	Ирж буцах 3 хүн
2	Багш нарын ажлын хөлс	ш	3	500,000	1,500,000	3 багш
3	Гарын авлага	ш	500 /5төрөл/	10,012	5,006,000	Оролцогч нарт
Нийт					7,226,000	

--ооо--